



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 09

Арвайхээр

Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын
мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.1, 7.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2024 онд хийгдсэн хяналт шалгалт, дотоод аудитаар тогтоогдсон 29,553,825 (хорин есөн сая таван зуун тавин гурван мянга найман зуун хорин тав) төгрөгийн акт, 1,717,825,975 (нэг тэрбум долоон зуун арван долоон сая найман зуун хорин таван мянга есөн зуун далан тав) төгрөгийн албан шаардлагыг баталгаажуулсугай.

2. Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орсон орлогыг "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай" хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөхийг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй, зориулалтын дагуу зарцуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


3. Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг тухайн жилийн татварын ногдуулалттай уялдуулан төлөвлөх, төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилд 50 хувиас багагүй, жилийн дүнгээр 100 хувиас багагүй байхаар үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хугацаа хэтрэлтийг бууруулах, зээлдэгч нарыг зээлээ хугацаанд нь төлдөг хэвшилд сургах, зээлийн үр дүн, ашиглалтыг эргэн тооцдог байх, зээлдэгч нарын мэдээллийг хоршоо хөгжүүлэх сангийн программд тухай бүр үнэн зөв оруулдаг байх, зээлийн хүүгийн авлагыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгахыг сумдын Засаг дарга нарт, эдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир)-д үүрэг болгосугай.

622901001

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (М.Эрдэнэчулуун)-д үүрэг болгосугай.

ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА
БӨГӨӨД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ